



БУЯНТ-УХАА СПОРТЫН УТУГ-ЫН
ДАРГА С.МӨНХСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.16 № 3/21 ЧАТ-САТ/2014/80/СЭНГА-ТММЗ

Хохирлыг төлүүлэх тухай

Буянт Ухаа спортын ордны 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Буянт Ухаа спортын ордны даргын 2013 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн урамшуулал олгох тухай 5 дугаар тушаалаар нягтлан бодогч С.Золзаяад урамшуулал олгосон боловч СЭЗСайдын 2002 оны 210 тоот тушаалын 2.2, 2.3-т зааснаар "урамшуулал нь албан тушаалын 2 сарын цалингаас хэтрэхгүй байна"-ыг зөрчиж 721,3 мянган төгрөгийг илүү тооцож авсан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12 "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих..." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 тоот тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Аудитаар илэрсэн 721,3 мянган төгрөгийг С.Золзаяагаар Буянт Ухаа спортын ордны Төрийн сан банк дахь 900035034 тоот дансанд өдрийн дотор нөхөн төлүүлж, биелэлтийг 2014 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Буянт Ухаа спортын ордны дарга С.Мөнхсүх, нягтлан бодогч Б.Жамцгэрэл нарт хариуцуулсугай.

АКТЫГ

ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР:
/Д.ГАНБИЛЭГ/

УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:

БУЯНТ УХАА СПОРТЫН ОРДОНЫ
ДАРГА
/С.МӨНХСҮХ/

НЯ- БО /Б.ЖАМЦГЭРЭЛ/